STUDIA
LINGUAE ET LITTERARUM
INSTITUYI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE
SCIENTIARUM REIPUPUBLICAE POPULI MONGOLICI

Tom. XIII Fasc.3

КИДАНЧУУДЫН БИЧГИЙН ДУРСГАЛ МОНГОЛООС ОЛДСОН НЬ

Х.Пэрлээ

Монгол гаралтан аймаг угсаатны бичиг үсгийн тухай сурвалж бичгийн мэдээ шинжлэх ухаанд мэдэгдсээр олон арван жил боллоо. Тэр тухай бичсэн олон хэлний эохиол бүтээл ч үлэмж нийтлэгдлээ.

Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн нэгэн чухал дурсгал-бичиг үсгийн дотроо Киданий бичиг үсэг эрхэм суурь эзэлж, эрдэмтэн мэргэд их ч ухаан зарж судалдаг болов. Түүний баримт материал нээгдэн олдох горь найдал тасраагүй л байна.

Монголд киданий бичгийн археологийн дурсгал байсан тухай XIII зууны эхэн мөчлөгөөс бичигт тэмдэглэгдсэн ба тэр дурсгалын бяцхан баримт олсноо эрдэмтдийн сонорт хүргэсэн билээ.[1] Түүнээс хойш Монголд Киданий бичгийн археологийн дурсгалыг зориуд хайх ажлыг эхлэж, тэр тухай бичгийн ба археологийн хомсхон мэдээ олсноо цэгцлэн мэдээлэхийг оролдоно.

I.Чин толгойн балгасны дээврийн вааран дээрх бичгээс

1951 онд улсын төв музейн түүхийн ангийн үзмэрийг шинэчлэн тавих үеэр Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Чин толгойн балгаснаас /1933-34/ малтлагаар олдсон олдворын дотор үл мэдэгдэх бичээстэй дээврийн ваарны хагархай байлаа.Тэр хагархайн өнгөн талын нэгэн сэжүүр дээр "Чин-толгой" гэж бал харандаагаар бичиж, хоёр хажуудь хар бэхээр "I6-20"гэж хоёр дахин дугаар-тэмдэг тавьжээ.Дээр нь байгаа бичээсийг ажиглавал, үл уншигдах хэдэн дурс бичээсийг дахин давтан гуйвайлган хэвдсэн байна./3-р зургийг үз/

Түүхийн сурвалж бичгийн мэдээг манай эртний судлалын мэдээтэй харьцуулж, археологич нар Чин-толгойн балгасыг X зууны үед холбогдох Кидан улсын үеийн /Хатуж хот/ "Чжэн-Чжоу" хот гэж тогтоосон билээ.

Монголын тухай сурвалж бичиг судрыг шүүрдэн үзэхэд XIII зуу-ны эхэн үед монголд ирсэн эрдэмтэн Чан Чуны "-Си-ю-Цзи" /" Ба-руун газар зорчсон тэмдэглэл"/ гэдэг номоос сонирхолтой мэдээ олдсон юм. Тэнд бичсэн нь: "Дөрвөн өртөө яваад баруун хойш гол гатлахад сайхан өвстэй, сайн устай гол мөрөн, үзэсгэлэнт уул хад зүг бүрт нь үргэлжилсэн тэгш тал нутаг илхэн харагдаж бай-на.Хотын турь эвдэрхий зүүнээс баруунаа хөглөрнө. Хотыг шинэ барьсан юм шиг гудамж,зээл нь тод ялгарахаар байна.Энэ барилга Чжун-Чжоу хотын байдалтай төстэй санагдавч босгосон гэрэлт хө-шөө байхгүй тул, хэзээ байгуулсан ямар хотын балгас болохыг то-дорхойлж болохгүй байна. Зарим хүн энэ хотыг Кидан нар байгуул-сан гэлцэнэ. Миний бие хөсрөөс дээврийн ваар авч үзэхэд нээрээ ч хятан бичиг байлаа"[2] гэжээ.

Чан Чуны гаталсан тэр голыг Туул гол мөн гэж эрдэмтэн нар маргалдсан байдаг. Туул голыг Чин толгойн чигтэй баруун хойш гатлахад замд Талын улаан хэрэм гэдэг Кидан хотын ор дайралд-на. Чан-Чуны хэлсэн газрын баримжаа Туулаас Чин толгой орох замтай нийлэлцэж байх тул, Чин толгойн балгас Чан Чуны хэлсэн дээврийн вааран дээр Кидан бичээстэй хот мөн болж байна.

Бичээсийг хэвт гаргасан байдлыг ажиглавал,гурван хэсэг төмөрлөг тамгаар модон хэвт хонхойлгон цохиж /тамгалж/ гаргасан байдал илэрхий байна. Кидан нарт модонд буюу шаварт үсэг там-галж гаргадаг үсгийн сан байсан бололтой. Ваар дээрх гурван үсэг тоосгочны нэр байж болмоор санагдана.

Энэ бичээсний эхний үсгийг хятадын "му-"мод" гэсэн эвхмэл /гор/ үсэг гэж бодоод нангиадаар уншиж болох боловч,бусад хоёр үсэг нь нангиадаар уншигдахгүй тул цөм гурвуулан кидан үсэг буюу тамган дүрс биз гэж үзсэн юм.[3]

Чин толгойн балгас бол Монголын гэрэлт хөшөөтэй байсан эртний цөөн хотын ор үлдцийн нэгэн нь болно.Чин толгойн бал-гасны хэдэн өрөг их шороон хэрмийн төвд том барилгын үүдэнд гэрэлт хөшөө суулгаж байсан хоёр чулуун мэлхий байхыг анхан 1926,1933 онд монголч Н.Н.Пошпе, археологич Д.Д.Букинич нар олж үзээд гэрэлт хөшөөг олох гэж бага малтлага хоёр удаа хий-гээд амжилт олсонгүй байжээ.

Д.Д.Кукиничийн гар тэмдэглэлээс үзвэл, том жижиг чулуун мэлхийн хэмээ нь,том мэлхий уртаар 1,32 м,өргөнөөр 1,20,1-44-

-I,20 м, өндрөөр 0,45-0,46 м, бага мэлхий нь уртаар I,06 м,өргөнөөр 0,97 м,өндрөөр 0,46 м[4] Мэлхийнүүд нар бороонд гэмтэж гадарга нь их л холторч мөлийснийг дурджээ.[5]

Тэнд их хэмжээний малтан шинжилгээ хийхэд тэр гэрэлт хөшөөнүүд илэрч юуны магад хэмээн монгол археологич нар горьдол төрсөөр байдаг юм. Учир нь Д.Д.Букиничийн малтлагаар мэлхийнүүд хуучин байрандаа биш өөр газарт шилжиж, ирсэн нь илэрсэн гэх тул,хөшөөнүүдийг өөр газраар малтан хайх нь зүйтэй ажээ.

2.Салбар уулын Бичигт Ханан/хаданд/ дээрх их бага бичээс

Салбар уул Хэрлэн голын сав газарт Өндөрхаан хотоос баруун тийш 30 км зайтай оршино. Хэрлэн голыг Монголд байгаа Киданы археологийн дурсгалаар хамгийн баялаг гэж болно. Түүний хоёр хөвөөнд зөвхөн Өндөрхаан хотын хавилцаа газарт: Зүүн хэрэм /Пибиголын хот/, Баруун хэрэм, Доод Улаан эргийн /кидан/ суурин, Модон Жаргалангийн хэрэм,Могнооны /Эрдэнэ уулын/ хэрэм, Хунт бүрдэний хүйс толгойн /суурин/-ы нураа ором сууръ байдаг. Эдгээр хот суурины үлдэц нураа нь Салбар уулаас 30-60 км зайд оршиж байжээ.

Салбар уулын Бичигт Ханан/хадан/-ы дэргэдүүр киданий үеийн олон /дөрвөлжин/ булш бий.Зарим нэгэн булшийг малтахад Х зууны үеийн хүрэл толь,харвуулын сумны төмөр зэв гарсан билээ.

Салбарын Ханангийн бичээсийн тухай мэдээ нь анхан XIX зууны эцсээр академич Радловын "Орхоны экспедицийн тайлан" бүтээлийн хавсралт "Монголын эртний зүйл" хэмээх орос герман хэлний атласад товчийн тэдий орсон байжээ.Монголд ардын хувьсгал мандаж, шинжлэх ухааны төв-Судар бичгийн хүрээлэнг байгуулсны дараахан мөнхүү хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, Салбарын уул хавьд нутаглаж байсан Ч.Бат-Очир биечлэн үзэж, Салбарын Ханангийн бичээсийг хуулж ирсэн ба I940 хэдэн онд Ц.Пунцагноров газарзүйн экспедицид оролцон явахдаа бас нэгэн хагас хуулга авчирчээ.

I952 оны 6-р сард энэ өгүүллийг бичигч Киданий хот судлах археологийн экспедиц удирдаж явахдаа Салбарын Бичигт Хананд ирж бичээсийг гараар хуулж дэргэд нь сийлсэн тамган дүрс-I6-ыг

зурж авсан юм.Түүнээс хойш Чехословакийн монголч эрдэмтэн П.Поуха тус бичээсийг сонирхон хуулж замын тэмдэглэл номдоо нийтэлжээ.[6] Гэвч тамган дүрсдийг хэвлэсэнгүй тул уг хуулга нь базаахгүй болсон бололтой.

1972 онд энэ өгүүллийг бичигт Зөвлөлт Улсын археологич эрдэмтэн Э.В.Шавкуновын хамт, Салбарын Бичигт Хананд очиж бичээсийг гүймэг үзэж, хуулж, дэргэдэх нэгэн булшийг малтсан билээ.

1975 онд энэ өгүүллийг бичигч Салбарын Бичигт Хананд тухитай ажиллаж,тодорхойлго бичиж, нарийн хэмжээ авсан юм. Тус бичээс их бага хоёр хэсгээс бүрдэл болжээ. Их бичээс нь 3 мөр,17 дүрс үсэг/18 ч байж магадгүй/,бага бичээс нь 1 мөр,7 дүрс үсэг юм.Бичээсийн их нь нийтдээ 34х74 см эзэлхүүн зайд дүрс үсгийг дээрээс доош,хадны толиог дагуулан мөр хоорондын ба дүрс үсэг хоорондын зайг харилцан адилгийгээр, /1-3, 4,5-6 см/, үсгийн тэг нь: өндөр 7,3-9,11-16,8 см өргөн -3,8-6,5, 7-9,10-16 см, гүнзгий 015 мм хонхойлгон сийлсэн байлаа. Бага бичээсийн үсэг хоорондын зай нь их бичээс мэт хэмжээтэй байлаа.

Их бичээс нь хандах хүний баруун гар талд,бага бичээс нь солгой гар талд тус тусдаа сийлэгдэжээ. Ажиглаж үзвэл,бага бичээс нь их бичээсийн тэтгэсэн он сар нь шиг сэтгэгдэл төрүүлж байна. Их бичээсийг ажиглавал,/солгой гар талаас хэлбэл/ 1 -р мөр нь бусдаасаа богино дөрөвхөн үгтэй боловч 2-р мөрөөс бага зэрэг өргөж дээдлэн тэтгэсэн байдалтай,2-р мөр нь 3-р мөрөөс бас бага зэрэг дээр сийлэгдсэн байна.Бичээсийн мөрүүдийг тийнхүү дээр,дунд, доогуур эхлэж сийлсэн байдал нь монголчуудын бичиг хэрэг хөтлөлтөнд чанд мөрддөг журмыг баримтлаж байсан ноёлох том хүний нийгэмд эзлэх байр эрх ямбыг харгалзан,түүний цол хэргэм алдар нэрийг буюу айлдсан,зарлиг буулгасан, захиран тушаасан үгийн эхний үсгийг дээр,дунд,доохноос эхлэн бичиж тэр хүний хүндэтгэлийг нарийн ялгадаг хэв журмыг санагдуулж байна. Дээрх мөрүүдийг байрлуулсан байдлаар баримтлаж, хоёр бичээсийг эхэн тал нь солгой талд байна гэж болох мэт.Гэвч эрдэмтэн шинжээчид Кидан бичгийг бүрэн тайлж уншсан цаг тухайд бидний таамнал зөв эсэх нь шийдэгдэх биээ./1-2-р зургийг үз/.

Энд тэмдэглэх нь зүйтэй нэгэн зүйл бол, Салбарын Бичигт Ханангийн бичээсний хавьд мөнхүү ханан хадны толионд 16 тамган

дүрс түс туслаа сийлсэн байсныг 1952 онд бүртгэж аль нь алинынхаа аль талд байсныг тодорхойлон зурж авсан бөгөөд 1972,1975 онд очиход тамган дүрсийн зарим нь нар бороонд гэмтэж будгэрч зарим нь холтрон оргүй алга болсон ба ганц нэгэн тамган дүрс хадны хаг досроос тодорсон байлаа. Энэ тамган дүрсийн тухай бусад тамган дүрсэдтэй холбож, дор жич нарийвчлан өгүүлэх болно.

3.Харбухын/Хадаасангийн/ балгасны дээврийн ваараан дээрх дүрс тэмдэг/бичээс/

1969 онд Монгол-Зөвлөлтийн Академийн хамтран гаргасан археологийн шинжилгээний анги нь нэгэн хэсэг болох Монголын түрүү үеийн нүүдэлчдийн археологийн дурсгалыг эрин хайх малтан шинжлэх багийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Цэрэндорж, Кидан гүрний /X-XI/ үеийн нэгэн хот болох Булган аймгийн Дашинчилэн сумын Харбухын /Хадаасангийн/ балгасаас нэгэн үл уншигдах тэмдэг/бичээс/ бүхий дээврийн ваарны өөдөс олжээ.

Тэр дээврийн ваарны өөдөс нь, бор саарал шавраар хэвдэж хийсэн, ар талдаа нэхмэлийн хээтэй далбан эм /доод/ ваар байжээ. Уг өөдсийг дервөн өнцөг тийш нь хэмжвээс 13 х 13 см,хамгийн өргөн нь 11,5 см, хамгийн нарийн нь 4,5 см/ зузаан нь 2,4 см байна.

Ваарны өөдсний өнгөн /гадна/ тал дээр нь хүний сүг дүрстэй тун тэстэй дервөн хэсэг зургаан сүг дүрс/ бичээс/ үлджээ. Зургаан дүрсийн нэг нь хагас, хоёр нь хос, нэг нь солгой гар талдаа бяцхан нэмэртэй болой./4-р зургийг үз/

Г.Цэрэндоржийн хамт явсан зөвлөлтийн доктор профессор Феодор-Давыдов, археологич С.Гришин нар дээрх олдворын бичээсийг хүний зураг гэж шууд үзсэн гэх бөгөөд бодвол тэд Кидан гүрний үеийн хотын ор үлдцээс кидан бичээстэй дээврийн ваар олддогийг мэдээгүй ажээ. Харбухын балгасаас зүүн тийш 18 км-д орших Чин толгойн балгасаас 1980 хэдэн онд кидан бичээстэй дээврийн ваар олдсоныг 1959 онд монголын судлалын нэгэн хэвлэлд нийтэлсэн болой.[10]

Г.Цэрэндоржийн олдвор дээрхи хэдэн сүг дүрс нь бидний үзэж байгаагаар хүний дүрс/ зураг/ биш, кидан бичээс бүхү овог аймгийн тэмдэг байж болно. Бидэнд бэлэн байгаа киданы бичиг үсгийн

санд манай сонирхон бүхий дээврийн ваарны бичээстэй төслөх зурлага үсэг байхгүй. Гэвч манд мэдэгдээгүй киданы үсэг байж болохыг бодолцоод олдвор дээрх дүрсийг киданы бичгийн зүйвэрлэх аргын үүднээс задлан үзэхэд кидан бичгийн үсэг зурлага зүйд их л төсөөлөг болж монголын малын тамга, тэмдгийн үндсэн дүрсүүдтэй ижилсэх төлөвтэй байна.

Тэр дээврийн ваар дээр уг ваарыг ухаалан сэдэвлэсэн мастерын алдар буюу шууд гардан үйлдсэн ваарчны нэрийг дахин давтан тавьсан байх гэж үзэлтэй.

4.Биндэр уулын Рашаан хадны дэргэдэх том чулуун самбарын тамган дүрсдийн доторхи хэдэн тэмдэг

Хэнтий аймгийн зүүн хойд нутаг-Батширээт сумын Биндэр уулын Рашаан хад хэмээх газарт шинэ чулууны үеэс эхлэн, тэндхийн хад чулуунд зурж сийлсэн үлэмж олон тамган дүрс бий.

Рашаан хадны тамган дүрсийг монголчуудын өвөг овгийн тамганы археологийн дурсгал гэж нэгэнт тогтоосон билээ. Рашаан хадны тамган дүрсийн дотор хэлбэрээрээ тамган дүрсээс онцгой бөгөөд сийлбэрийн чадвараар ялгарах хэдэн дүрс байдаг юм.Тэдгээр дүрс нь киданы бичгийг санагдуулдаг тул энд хавсарган зурж толилуулъя./6-р зургийг үз/.

Рашаан хадны дэргэдэх тамган дүрс сийлсэн том чулуун самбарын хавийг малтахад киданы шавар савны хагархай олддог ба Рашаан хадны ойр /10 км-д/ орших Өглөгчийн хэрэм хэмээх эртний чулуун бэхлэлтийг археологич нар Киданы үеийн хэмээн тогтоожээ.Бас Рашаан хаднаас баруун тийш 20-оод км-д байх Жаргалантын голын боом-Тегс-өндөрийн өвдөг хэмээх газар кидан булш нилээд олныг олж малтан шинжилсэн юм.Учир иймд, Кидан нар Рашаан хаданд бусад монгол аймгийн нэгэн адил тамга-үсэг сийлэн дурсгал үлдээсэн байж болно.

5.Хэрлэн Барс хот-I-ийн кидан хөшөө

Нангиадын Мэ-гу-ю-му-цзи хэмээх чухал зохиолд /орос орчуулганаас сийрүүлбэл/: "Далее,автор Хоу-чу-сай-цзи замечает, что во владениях Далай-бэйцзы есть город Барс-хотонъ.В городе есть весьма большая,запустелая кумирня... Подле капища находится памятник с надписью,большая часть буквъ которой обвали-

валась,за исключением 2-3 хъ, которые еще можно временнъ династии Ляо /907-1119 г.по Р.Х/" гэсэн байдаг.[8]

Хэрлэн Барс хот -I-ийг 1954.1955 онд их хэмжээгээр малтан шинжлэхэд тэр дурдсан кидан бичээстэй хешөө олдоогүй билээ.Гэвч тэр хешөөний тухай мэдээ зоалт нь Монголд байгуулсан киданчуудын хот сууринд босгосон хоёрдахь гэрэлт хешөөний мэдээ болох тул сонин бөгөөд Хэрлэн Барс хот -I нь тэр цагтаа их л чухал газар байсны нэгэн гэрч болно.

6.Салбарын Ханан хадны кидан бичээсний дэргэдэх тамган дурсдийн тухай

Аливаа бичиг үсгийн гарал,түүхийг судлан боловсруулахад овгийн тамган дүрс чухал сурвалж хэрэглэхүүн болдог билээ.Доор дурдсан кидан бичээсний дэргэдэх /овгийн/ тамган дүрсэд нь хэдүй цөөхөн 19 боловч монгол аймгуудын үсгийн түүхэнд мөн монгол овгуудын тамган дүрсэдтэй холбогдол байх эсэх тухай асуудалд зохих хариулт олохыг эрмэлзэх нь эрдэм шинжилгээний нэн тустай ажил болно.

Салбарын Бичигт Ханангийн 19 тамган дүрсийн Рашаан хад, Мөрт,Цагаан гол зэрэг 6 газрын хадны тамган дүрсэдтэй Хүннү, Монгол овгийн тамган дүрсэдтэй, түргэний руни үсэг монгол овгийн тамгатай тус тус тулгаж үзэхэд I-9 удаа ижилссэн,буюу хувилбар адилшаалтай байлаа./5-р зургийг үз/ Үүнээс зэрэгцүүлэн бодвоос Салбарын Бичигт Ханангийн /Кидан/ тамган дүрс үлдээгсдийг өвөг уг удам нь бусад газрын хадны тамган дүрс хоцроогсодтой нийтлэг гаралтай бөгөөд хожим монгол нэрийн дор ондоошин үлдсэн гэж урьдчилсан дүгнэлт хийж болмоор байна.

7.Эрдэнэ/овооны/ уулын хадны үл мэдэгдэх бичээс

1973 онд манай "Гурван голын" археологийн шинжилгээний анги Хэнтий аймгийн Мөрөн сумын нутгийн зүүн хойд захад орших Эрдэнэ /овоо/ уулын оройн ханан хаданд хар бэхээр бичсэн нангиад бичээсийг үзэж хуулан авах үедээ тэр бичээсний доод талд хоёр үл мэдэгдэх бичээс байхыг ажиж мэдсэн юм.

Нангиад бичээс хэдийгээр зарим үсэг нь баларсан боловч, үлдсэн мөрүүдийг манай нангиадач нар уншиж,ямар нэгэн явуулын хүн Эрдэнэ уулаад иржээ. Нангиад бичээсийг үлдээсэн хүний нэр,

он байхгүй боловч, эртний дурсгалт энэ "агуйд" /Ханан хадны хөмөгт/ ирсэн тухай санааг илэрхийлсэн нь, Эрдэнэ уулаад байгаа эртний дурсгал /бидний ажигласан хоёр/-ын сургаар тэнд тэр нангиад хүн ирсэн байжээ.

Хоёр үл мэдэгдэх бичээсийг дээрээс доош хар бэх мэт юмаар бичжээ.Бичээсүүдийн дээгүүр хадны олон оны хур уусмал нимгэн хаг бүрхэн тогтоож, үсгийг харж танихад бэрх болгожээ. Бичээсийг хоёр газар тус тусад нь бичжээ. Нэгэн бичээс нь I-I2/ I3 дүрс үсэгтэй I2 мөр, нөгөө нь I0-II дүрс үсэгтэй 7 мөр байсан бололтой гэж багцааллаа.

Хадны хаг нь нимгэн /шингэн/ шил мэт гилгэр боловч, бараг бүх үсгийн дүрсийг муухан ч ялгахад бэрхтэй болгосон учир, бид I-II мөрт бичээсний I-р мөр /магнай/-ийн I үсэг 2-р мөрийн I2 үсэг/ Энэ мөрт I3 үсэгтэй байсан боловч I үсэг бүр балархай/, I2-р/ эцсийн/ мөрийн I үсгийг тус тус дуурайлган хуулаа./ 7-р зургийг үз/ Бид хоёр өдөр шаргуу ажиллаж тэр хоёр бичээсэнд 40 гаруй дүрс үсэгтэй байж гэж үзсэн юм.

Хоёр бичээсийг баруун гар талаас эхлэн доош бичсэн болоо гэх сэдэв байгаа нь I-р мөрийн ганц үсгийг бусад үсгийн мөрөөс дээр магнай болгож бичсэн явдал юм.

Тус бичээсүүдийг манай эрдэмтэн нар юу боловчиг нангиад бичээс биш, кидан бичээс байж мэднэ гэж үзсэн юм. Тийм учраас дээрх хоёр бичээсийг энд хавсарган нийтэллээ.

Ном зүй

I.Пэрлээ./Улаанбаатар/.Чин толгойн балгасны бичигт ваар."Студиа Монголика". Томус Г,фасцикулус 5.УБ.,I959,3-6-р тал.

Х.Пэрлээ.Хятан нар,тэдний монголчуудтай холбогдсон нь,УБ.I959. 85-р тал.


Х.Пэрлээ.Монгол Ард Улсын эрт,дундад үеийн хот суурины товчоон. УБ..I96I.57-р тал.

2. 王國維。校注長春京眞人西遊記。北隆福寺街文殿閣書莊。

又西趨。西北渡河。其旁山川皆秀麗。水草且豐美。東西有故城基址。若新街衢。巷陌可辨。制作頗中州。歲月無碑刻可考。或云契丹所建。既而地中得古瓦。上有契丹字。

3.Х.Пэрлээ /Улаанбаатар/.Дээр дурдсан зохиолд үз.
4.Д.Д.Букинич.Общии отчет археологическим работам за 1933 и 1934 г.Машинопись, архив Института истории АН МНР. 32 л.
5.Д.Д.Букинич.Описание работ археологической партий экспедиции НИК-а 1934 года. Машинопись,1 л,Х.Пэрлээ.Хятан нар 85-р тал.
6.П.Поуха Тринацат тисиц километру./чех хэлээр/ Аутем,паролодиа летадлем.Прага, 1957.160-р тал.
7.Х.Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь./Түүх угсаатны зүйн туршиц судалгаа/.УБ.,1976.25-263-р тал.
8.Чжан-Му. Мэн-гу-ю-му-цзи. Перевод Попова.СПб., 1891, стр. 392-393.

ХАВСРАЛТ



I-р зураг

Салбарын бичигт

Ханан

/Их бичээс/



2-р зураг


Салбарын Бичиг

Ханан

/Бага бичээс/




3-р зураг.Чин толгойн балгасны
дээврийн ваарны бичээс



4-р зураг.Харбухын балгасны
дээврийн тэмдэг


6-р зураг.Салбарын Бичигт Ханангийн тамган дүрсэл тамгийн загвар хээ

6-р зураг. Салбарын Бичигт Ханангийн тамган дурсэд тэдгээрийг зарим газрын тамган дурсэдтэй харагдуулан үзсэн Хүснэгт





6-р зураг.Рашаан хадны чулуун салбарын тамган дүрсээс

А



Б





7-р зураг. Хэнтий аймгийн Мөрөн сумын зүүн хойд захын Эрдэнэ уулын /овооны/ Хадны бичээс

РЕЗЮМЕ

Некоторые памятники Киданьской письменности в Монголии Автор сообщает в статье о ниженазванных некоторых памятниках Киданьской письменности, обнаруженных Монгольскими археологами из средней и восточной Монголии:

I. Надписи /иероглифы/ на обломке кровельной черетицы из развалин Чин-Толгоя-Киданского города Хатун-хотона/китайское название Чжен-Чжеу/ на территории Дашинчилен сомона Булганского аймака.

2. Большая и маллая надписи на скале гор Салбарын Бичигт Ханана на территории Мурэн самона Кентейского аймака.

3. Знаки на обломке кровельной черетицы из развалин Киданского города на берегу Р. Харбухын гола Дашинчилэн самона Булганского аймака.

4. Некоторые знаки /пероглифы/ из петроглифов Биндэрийн Рашаан хада на территории Бат Ширээт сомона Кентейского аймака.

5. Тамгаобразные знаки на скале гор Салбарын Бичигт Ханана на территории Мурэн сомона Кентейского аймака.

6. Две надписи /пероглифы/ на скале горы Эрдэнэ/Овоо/ уулы на северовосточной границе Мурэн сомона Кентейского аймака

Кроме того автор также осведомляет данные о трёх исчезнувших стел с киданьскими надписями.

БНМАУ
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

XIII боть 1-25 дэвтэр

ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ

ШУАХ

Улаанбаатар хот
1979

STUDIA
LINGUAE ET LITTERARUM
INSTITUTI LINGUAE ET LITTERERUM ACADEMIAE
SCIENTIARUM REIPUBLICAE POPULI MONGOLICI

Tom. XIII Fasc.I-25

В библ. вмес. кроме "—".

ХЭЛ ЗОХИОЛЫН СУДЛАЛ

проф. А. ЛУВСАНДЭНДЭВ

Улаанбаатар хот
1978

I

STUDIA

LINGUAE ET LITTERARUM

INSTITUTI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE

SCIENTIARUM REIPUBLICAE POPULI MONGOLICI

Tom.XIII Fasc.I

АГШИЛГА,ЭГШИЛГИЙН ГИЙГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

Ш.Лувсанвандан

Хуучин монгол бичгийн зөв бичих дүрэмд эр эгшигт үгнээ тохиолдох, хэлний гүн угийн эм эгшигт үгэнд тохиолдох,хэлний гүн бус угийн гэж ялгаж байжээ.Тэгэхдээ зохих үсгийг эгшгийн өмнө хоёр цэгтэй,эгшгийн дараа үеийн эцэст хоёр цэггүй бичдэг байжээ. Гэтэл ойрдын тод үсгийн зөв бичих дүрэмд эр эгшгийн өмнө буюу эм эгшгийн өмнө үеийн эцэст эр,эм гэж ялгалгүй бичих журам тогтоон,дервөлжин үсгийн зөв бичих дүрэмд эр эгшгийн өмнө ү буюу ɋ эм эгшгийн өмнө ɣ орох боловч үеийн эцэст эр эгшигт үгэнд ɣ - ийг арвин хэрэглэж байжээ. Энэ ɋ нь орчин цагийн монгол хэлний шүргэх х болсон эртний монгол хэл, дундад эртний монгол хэлний чанга,хамжих ɋ биш,харин тэр цагийн монгол хэлний сул, дуутай ү гийгүүлэгчийн хувилбар болно. Монгол хэлний үгийн эцсийн дуутай,сул гийгүүлэгч дуугүй чанга болдог тул дуутай, сул гийгүүлэгч ү -ийг дуугүй, чанга ɋ -гээр тэмдэглэсэн байж магадгүй. Орчин цагийн монгол хэлний халх аялгуунд ийм үе төгсгөх агшилга ү, эгшилгэ ɣ -ийг хэрэглэж байсныг одоо урт, хос эгшгийн дараа,дуутай, сул гийгүүлэгч, эгшгийн өмнө дуутай,хамжих ɣ ,урт буюу хос эгшгийн дараа,дуугүй, чанга гийгүүлэгчийн өмнө дуугүй, сул,хамжих ɣ , богино эгшгийн дараа, дуугүй, чанга гийгүүлэгчийн өмнө хэлний гүн бус угийн шүргэх х болж хэлэгднэ.Энэ мэтээр нэг фонемын хоёр хувилбар болж байсан ү , ɣ хоёр биеэ даасан фонем болж, харин хоёр биеэ даасан фонем болж байсан дуутай хамжих ɣ , дуугүй шүргэх х хоёр нэг фонемын хоёр хувилбар болсон байна. Орчин цагийн монгол хэлэндү нь дэвсгэрлэхгүй гийгүүлэгч болж, ɣ нь эр,эм эгшигт үг гэж ялгахгүй дэвсгэрлэдэг бол

жэ. Жишээлбэл, baγār, bagār, baγās, baγīgi, bagīgi, baγīŋ, baγădā, baxtā, baxĭi, baxt^, baxts^, extsə, óxsə, óxxə, tagl^, bóglə, egnə, bagā, āgtăō, tŏĕgtŏŋ гэх мэт. Энд х нь монгол хэлэнд биеэ даасан фонем болдог х фонем биш, g фонемын хувилбар болно. Монгол хэлний жинхэнэ х фонем нь дэвсгэрлэж ордоггүй, гэтэл g фонемын хувилбар болсон х нь дэвсгэрлэж орсон байна. ɣ фонемын нөгөө хувилбар х болсны шалтгаан нь хэрэв дараа нь дуугүй чанга, хамжих гийгүүлэгч байсан бол дуутай ɣ нь түүнтэй дуугүйн талаар ижилсэвч бүтцийн талаар ондоошиж дуугүй, шүргэх х болсон байна. Хэрэв дараа нь дуугүй, чанга шүргэх гийгүүлэгч байсан бол дуутай, хамжих ɣ нь дуугүйн талаар, бас бүтэхийн талаар түүнтэй ижилсэн дуугүй, шүргэх х болсон байна. Энэ зарим фонемын хувилбар өөр фонемын хувилбартай тохирох удаа байдгийг харуулж байна. Ийм газар дан харьцаагаар нь учрыг нь ойлгох хэрэгтэй байна. Урт, хос эгшгийн дараад нь шүргэх х болдоггүй нь угтаа урт, хос эгшиг нь aγā, egē, āγi, гэх мэтээр хоёр үе болж байсны нөлөө болно. Энэ нь олон үетэй үгийн сүүлийн үеийн дэвсгэрийн ɣ, х болдоггүйтэй адил байна. Жишээлбэл, xerĕgtĕ, adăgt^, elbĕgtē, xerégtsē гэх мэт.

Монгол хэлний г-гийн төрлийн үсгийг хуучин монгол бичигт бүгд найман хувилбараар тэмдэглэж байсан нь эр эгшигт үгэнд тохиолдох таван хувилбар, үүнээс эгшгийн өмнө тохиолдох гурван хувилбар үеийн эцэст тохиолдох хоёр хувилбар, эм эгшигт үгэнд тохиолдох гурван хувилбар үүнээс эгшгийн өмнө тохиолдох хоёр хувилбар, үеийн эцэст тохиолдох нэг хувилбар болно. Эдгээр найман хувилбар нь найман үсэг биш, нэг үсгийн /графем/ найман хувилбар /аллограф / болно. Нэг авианы зарим хувилбар нөгөө авианы зарим хувилбартай тохирдогийн адил, нэг үсгийн зарим хувилбар нөгөө үсэг, мөн үсгийн зарим хувилбартай адил байж болно.

РЕЗЮМЕ

В статье анализируется варьирование согласной фонемы " q " фонема " γ " обозначалось в письме в 8 вариантах, согласно точке зрения автора, они не являются графемой, а 8 аллографах одной графемами.

II.Зохист аяшгууны толийн тогтоох дуршлыг тодруулагч /х.44а 5-44б 2 /

I2.YYл

I3.Тэнгэрийн дуу

I4.Тогосны ёгт нэр

I5.Шар шувууны ёгт нэр

РЕЗЮМЕ

В этой статье автором сделан вывод о том, что если индийские и тибетские поэты применяли принципы "Кавьядарши" Дандина главным образом в составлении легенд о планетах и богах, то поэт Ишсамбуу творчески использовал эти принципы в описании реалной жизни данного общества.

ГАРЧИГ

Ш.Лувсанвандан Агшилга,эгшилгийн гийгүүлэгчийн тухай . . . 3
Ш.Лувсанвандан Монгол хэлний бүтэцийн тухай асуудал . . . 5
Х.Пэрлээ Киданчуудын бичгийн дурсгал монголоос олдсон тухай 15
Б.Базылхан Монгол,казах хэлний үгийн сангийн харьцааны асуудалд 31
Л.Балдан Уран зохиолд өнгө заасан үгийг хэрэглэх асуудалд 47
Э.Вандуй Үгийн эхний зарим гийгүүлэгч гээгдэж байгаа нь . 54
Ц.Шагдарсүрэн Дөрвөлжин бичгийн үсэгзүйн нэгэн онцлог хослол 57
М.Шинэхүү Хангидайн хадны түрэг бичээсийг дахин нягталсан нь 65
М.Базаррагчаа "ав" хэмээх үгийн уттын хувилбарын тухай. . .70
Ц.Баярсүрэн Монгол хэлэнд орсон харь гаралтай үгийн дуудлагын тухай 82
П.Бямбасан Үг давтахын нэгэн учир 87
Г.Гантогтох Халхын аялгууны хамжин шүргэх гийгүүлэгчийн сэлгээ 98
Г.Жамбалсүрэн Монгол хэлний нэгэн зүйл тодотголын тухай 102
Ж.Сэржээ Монгол хүний нэрийг судлахад дохионы онолыг хэрэглэх нь 111
С.Харжаубай Тэсийн гэрэлт хөшөө 117
Д.Чойжилсүрэн Нэг үйл үгийн хувилбар 125
Ц.Дамдинсүрэн Рамаяна в Монголии 134
— С.Лувсанвандан К проблеме образа нового человека,коммуниста . . 146
— Л.Түдэв Идеи интернационализма и образ интернационалистав монгольской литературе 158
— Д.Цэдэв Дашдоржийн Нацагдоржийн уран бүтээлийн онцлог . 208
— Д.Цэнд Д.Сэнгээгийн амьдрал ба уран бүтээл. 227
Д.Цэрэнсодном Шүлэг найргийн аялгуу хөгжмийн тухайд 239
— Р.Гүрбазар Уранзохиолын орчуулгын ажлын үе шатны асуудал 251

Д.Өлзийбаяр Хорь,гучаад оны туужийн уран чадварын асуудалд 260

Л.Хүрэлбаатар Инсамбуугийн нэгэн зохиол"Зохист аялгууны тольтой холбогдох нь 270

ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ
Редактор Э.Вандуй

Техник редактор хийж хуулан
бичсэн Г.Сэржмядаг
Бичилтэнд 1978 оны 4 сард
Фото бэлтгэлд 1978 оны 7 сард
орж 1300 хувь хэвлэв.
Цаасны хэмжээ 70х108/16
ХХ 17,5. ХНХ 24,74. ТХ 10,0
В 66951. Хг № 102/78.За № 251

Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр
Улаанбаатар.Нэгдсэн ундэстний гудамж 19.

Үнэ 14 төг 80 мөн